

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц

Архангай аймгийн хэмжээнд нийтдээ Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 85 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:Хөдөө аж ахуйн салбарт-17, Байгаль орчны салбарт-24, Боловсрол соёлын салбарт-11, Нийгмийн халамжийн салбарт-7, Хууль зүйн салбарт- 9 , Эрүүл мэндийн салбарт-13, Санхүү, үйлдвэрлэлийн салбарт- 3 хөтөлбөр хэрэгжиж байна.

Малын эрүүл мэнд, Англи хэл, Бичиг үсгийн үндэсний хөтөлбөр /17/, Зайны сургалт, Сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр /15/, Ногоон хувьсгал, Монгол бичиг, Малын чанар сайжруулах үндэсний хөтөлбөр /14/, Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр/13/, Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр/12/, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах ; “Сүү” үндэсний хөтөлбөр/11/, Морин хуур, уртын дуу; Хөдөөгийн айл, өрхийн цахилгааны эх үүсвэр, мэдээллийн хэрэгслийн хангалтыг сайжруулах; Усны тухай үндэсний хөтөлбөр; “Атрын 3 дахь аян”/10/ зэрэг үндэсний хөтөлбөрүүд аймгийн хэмжээнд 10-17 суманд хэрэгжиж жигд сайн буюу зарим тодорхой үр дүн гарч эхэлж байна.

Монгол хөөмий, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Биологийн төрөл зүйлийг хамгаалах, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай, Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх, Сохорлоос сэргийлэх, тэмцэх, Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг үндэсний хөтөлбөр зөвхөн нэг суманд л хэрэгжиж байгаа нь харьцангуй хангалтгүй гэж үзэж болохоор байна.

Нийт салбарын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хувиар авч үзвэл 16 хөтөлбөр - 70-80%, 21 хөтөлбөр - 60-70%, 46 хөтөлбөр - 40-60%- тай байна

Зарим үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт удааширч, саатсан , хэрэгжихгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн эх үүсвэр байхгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт, санал, санаачилга дутаж байгаатай холбоотой юм.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдлыг салбар салбараар нь гаргаж үзье.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР

- 1.Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр/1998, УИХ-29/
2. Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр
/1996, ЗГ-163/
3. Усны тухай үндэсний хөтөлбөр /1999, ЗГ-43/
4. Хог хаягдлыг бууруулах тухай үндэсний хөтөлбөр/1999, ЗГ-50/
5. Агаарыг хамгаалах үндэсний хөтөлбөр /1999, ЗГ-82/
6. Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр /1998, ЗГ-129/
7. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр /2000, ЗГ-120/.
8. Ойн тухай үндэсний хөтөлбөр /2001, ЗГ-248/
9. Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх
хөтөлбөр /2002, ЗГ-182/
10. Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл
ажиллагааны хөтөлбөр /2002, ЗГ-105/
- 11.Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр
/2003, ЗГ- 121/
- 12.Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр/2003, ЗГ-141/
- 13.Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр /2005, ЗГ-44/
- 14.Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр
/2006, ЗГ-99/
15. Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр
/2008, ЗГ-84/
16. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл
хөгжүүлэх хөтөлбөр /2007, ЗГ-96/
17. Цоохор ирвэс үндэсний хөтөлбөр /2005, БОС-195/
18. БОАЖЯ-ны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2009, БОАЖС-249/
19. ТАХ-ийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр
/2009, ТНБД-115/
20. ТАХ-ийн сургалтын хөтөлбөр /2009, ТНБД-115/
21. Чанарын болон байгаль орчны удирдлага(менежмент)-ыг дэмжих
үндэсний хөтөлбөр/2002, ЗГ-146/

22. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр /2006, ЗГ-309/
23. Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөр /2001, БОС-247/
24. Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр /2008, 267/

Архангай аймагт байгаль орчны салбарт Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол болон Байгаль орчны сайдын тушаалаар батлагдсан 24 хөтөлбөр хэрэгжиж байна. Байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хувиар авч үзвэл: 80%- 1 хөтөлбөр/Усны тухай үндэсний хөтөлбөр/, 60-70%-9 хөтөлбөр , бусад хөтөлбөрүүдийн хувьд 40-60%-тай байна.

Ус хөтөлбөрийн хүрээнд булаг шандыг тохижуулах ажлыг тогтмол хийж байгаа бөгөөд жилд 30-40 булаг шандыг тохижуулж байна. Усны тоо бүртгэл, чанарын хяналт шинжилгээний хувьд 17 сумын нутагт 9 усны харуул, 4 цаг уурын станц, 13 цаг уурын харуул ажиллуулан усны шинжилгээг хийж байна. Усыг зүй зохистой ашиглах, хэмнэх зорилгоор аймгийн төвийн орон сууцны байруудад оршин суугаа 500 гаруй айл өрх, албан байгууллагын 70 хувьд усны тоолуур тависан.

Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд Өгийнуур, Хотонт, Хашаат сумдад 1500 ширхэг улиасны суулгацыг, тарих аргачлалын хамт хүргүүлсэн. Цэнхэр сумын Орхон багт үйлдвэрлэл явуулж байгаа алтны компаниудыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлж байна. Бүх сумдын үлийн цагаан оготны судалгааг хийж, ИТХ-д оруулж, механик болон авиа химийн аргаар 25000 га газарт устгал хийсэн байна.

Хог хаягдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд:

Аймгийн хэмжээнд хог хаягдлыг бууруулах талаар бүх сумдын хатуу, аюултай хог хаягдлын тоо бүртгэл, хог хаягдлын дахин боловсруулалтын судалгааг гарган байгаль орчны нэгдсэн санд оруулсан. Мөн Эрдэнэбулган сумын хот тохижуулах Хасу Мандал компани гялгар уут, хуванцар сав боловсруулах үйлдвэр байгуулсан нь сайшаалтай байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

1. Хөдөөгийн айл, өрхийн цахилгааны эх үүсвэр, мэдээллийн хэрэгслийн хангалтыг сайжруулах дунд хугацааны хөтөлбөр /1995, ЗГ-49/
2. Нэг суурин-нэг бүтээгдэхүүн хөтөлбөр/2005, ЗГ-138/
3. Малын чанар сайжруулах хөтөлбөр/2006, ЗГ-93/
4. Экологийн цэвэр бүтээгдэхүүн хөтөлбөр /2006, ЗГ-50/
5. Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр /1999, ЗГ-64/
6. Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр /2001, ЗГ-242/
7. Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр/2009, ЗГ-32/
8. “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр 2- р шат /2004, ЗГ-169/
9. “Сүү” үндэсний хөтөлбөр /2006, ЗГ-239/
10. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр/2003/
11. Фермерийн аж ахуйг дэмжих хөтөлбөр/2002, ЗГ- /
12. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх үндэсний хөтөлбөр /1998, ЗГ-103/
13. Малын тэжээл хөтөлбөр /2008, ЗГ-283/
14. “Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр /2008, ЗГ-70/
15. Ноос” дэд хөтөлбөр /2001, ЗГ-26/
16. “Арьс шир” дэд хөтөлбөр /2001, ЗГ-114/
17. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр /2005, ЗГ-64/

Манай аймагт хөдөө аж ахуйн салбарын 17 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 7 хөтөлбөр -70-80%, 8 хөтөлбөр -60-70% үлдсэн 2 хөтөлбөрийн хувьд хэрэгжилт нь 40-60% байна гэж үзэж болохоор байна.

Атрын 3 дахь аян тариалангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 4000 гаруй га газарт үр тариа, 5.84 га-д төмс, 130 га-д ногоон тэжээл тариалж 2395 тн үр тариа, 1103 тн хүнсний ногоо, 3283 тн төмс хураан авлаа.

Тариалангийн талбайг 2,2 дахин нэмэгдүүлж хураан авсан ургацын хэмжээ 22%-р өссөн байна. Сум бүрт 20 тн багтаамж бүхий зоорь барьж ашиглалтанд орууллаа.

Малын эрүүл мэнд хөтөлбөр хэрэгжснээр 2009 онд аймгийн 19 суманд хувийн хэвшлийн 34 мал эмнэлэгт 90 гаруй малын эмч ажиллаж малын халдварт боом, галзуу, цусан халдвар, шөвөг яр, сохор догол, зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд -1378.3 мянган мал, паразит өвчний эсрэг арга хэмжээнд - 1196.5 мянган мал хамруулсан. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, лабораторийн шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 152.7 сая төгрөг зарцуулсан байна.

Нэг суурин-нэг бүтээгдэхүүн хөтөлбөр хэрэгжих хугацаанд аймагт жижиг, дунд үйлдвэрийг бий болгож шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд анхаарч дотоодын хөрөнгө оруулагч нар болон олон улсын хөтөлбөр, төслийн байгууллагатай хамтран Ихтамир суманд сарлагийн хөөврөөр сүлжмэл бүтээгдэхүүн хийх, аймгийн төвд мах боловсруулах үйлдвэр, талх нарийн боовны цех баригдан ашиглалтанд орж хэд хэдэн сумдад эсгийн урлал дагнан эрхэлдэг нөхөрлөлүүд бий болж үйл ажиллагаа явуулж байна.

Тухайн хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ, Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөрийн нэгжтэй хамтран “Архангай-түншлэл” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж хэвшсэний үр дүнд Архангайн гэсэн тодотголтой брэнд бүтээгдэхүүнүүд бий болж зах зээлд өөрийн байр суурийг эзлэн хэрэглэгчдэд танил болон үйл ажиллагаа нь улам өргөжихийн хирээр бүтээгдэхүүний чанар улам сайжирч байна.

Үүнд:

Өндөр-Улаан сумын “Цагаан идээ”

“Флом” нөхөрлөлийн эсгий урлалын бүтээгдэхүүн

Хашаат сумын “Модон сийлбэр”

Цахир сумын “Чулуун сийлбэр шатар” .

БОЛОВСРОЛ СОЁЛЫН САЛБАР

1. Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр /2004, ЗГ-244/
2. Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр/2001, ЗГ-120/
3. Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр /2008, ЗГ-316/
4. Зайны сургалтын үндэсний хөтөлбөр /2002, ЗГ-14/
5. Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр /2008, ЗГ-293/
6. Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр /2006, ЗГ-194/
7. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр /2008, ЗГ-196/
8. Морин хуур, уртын дуу үндэсний хөтөлбөр/2005, ЗГ-43/
9. Монгол хөөмий хөтөлбөр/2007, ЗГ-159/
10. Монголын уламжлалт бий, биелгээ хөтөлбөр/2009, ЗГ-10/
11. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр/2007, ЗГ-303/

Боловсролын салбарт манай аймагт 11 хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнээс 8 хөтөлбөр- 70-80%, 2 хөтөлбөр- 60-70%, 1 хөтөлбөрийн хэрэгжилт 40% тай байна. Боловсрол соёлын салбарын хөтөлбөрүүдийн хэрэгжилт бусад салбарыг бодвол харьцангуй гайгүй явж байна.

Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 19 суманд “Гэгээрэл” төвийг байгуулж . зайны сургалтын боловсон хүчин бэлтгэх чиглэлээр аймгийн хэмжээнд 20 багш бэлдэж, зайны сургалтын танхимын сургалтанд багш, ажилчид төдийгүй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагчид хамрагдаж байна.

Тухайн хөтөлбөр хэрэгжснээр аймгийн хэмжээнд 2009-2010 оны хичээлийн жилд 2-5 хүртэлх насны 6400 хүүхдээс 4687 буюу 73% -ийг СӨБ-д хамруулсан байна. Зайны сургалтын танхимд зайны сургалтаар 2009 онд нийт 10 гаруй байгууллага аж ахуйн нэгжийн 160 гаруй ажилтан албан хаагчид сургалтанд хамрагджээ.

Англи хэлний үндэсний хөтөлбөрийн хүрээнд багш боловсон хүчний чадавхийг сайжруулах зорилгоор англи хэлний 31 багш вакуумжуулсан 21 хоногийн сургалтанд хамрагдснаас 5 багш “А” үнэлгээтэй шалгагдаж олон улсын жишигт нийцсэн англи хэлний багшлах эрхийн сертификат авч давтан сургалтанд хамрагдах эрхтэй болсон. ЕБС-ийн 3 сургууль, Багшийн коллеж интернетийн кабинеттай болж англи хэлний онлайн олимпиадад амжилттай оролцож байна. АНУ-ын Арлингтон мужид амьдардаг Архангайн иргэдтэй холбоо тогтоож Хүмүүн-1 болон Цэнхэр сумын сургуульд англи хэлээр хэвлэгдсэн 250 ном олгосон байна. Англи хэлний анхан болон дунд шатны сургалтын хөтөлбөр боловсруулж 150 хүнд зохих шатны сургалт зохион байгуулсан байна.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр хэрэгжснээр домогт “Тайхар” чулууг төвийн бүсийн аялал жуулчлалын чиглэлд хамруулж боржин чулуун дурсгалын самбар босгож, сумдын соёлын төвүүд 12 үл хөдлөх дурсгалд хайс хамгаалалт хийж, 11 сумын соёлын төв түүх соёлын дурсгалаа зурагжуулан аймаг, сумын бүртгэл-мэдээллийн санд оруулаад байна. Хайрхан, Өндөр-Улаан, Ихтамир сумдын нутагт орших Хүннүгийн язгууртны булш, буган чулуун хөшөөнүүдийг хамгаалалтын бүс тогтоолгохоор координат зураг, холбогдох материалыг БСШУЯ-ны СУГ-т хүргүүлээд байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР

1. Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр
/2006, ЗГ-150/
2. Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр/2005, ЗГ-245/
3. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр /2005, ЗГ-246/
4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 3 дахь хөтөлбөр
/2007, ЗГ-52/
5. Иод дутлын эмгэгтэй тэмцэх 3-р хөтөлбөр /2007, ЗГ-85/
6. Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
/2002, ЗГ-251/
7. Сохорлоос сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр /2000, ЭМС-191/
8. Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөр

/2000, ЭМС-194/

9. Хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөр/1997, ЗГ-80/

10. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр

/2002, ЗГ-129/

11. Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр /2007, ЗГ-150/

12. Хүн амын бие бялдарыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр /2002, ЗГ-139/

13. “Эрүүл мэндийн салбарын хөгжил-3” хөтөлбөр

Манай аймгийн хувьд эрүүл мэндийн салбарын 13 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 4 хөтөлбөрийн хэрэгжилт нь 60-70% тай, бусад хөтөлбөрийн хувьд 40-60%- тай байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх, сум, хувийн хэвшлийн эмнэлгүүд жирэмсний хяналт болон жирэмсэн, төрөх үеийн тусламж, өсвөр үе БЗДХ зэрэг НҮЭМ-ийн тулгамдсан асуудлаар хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна.

Аймгийн 18 сумын 14 нь зөөврийн эхо аппаратаар хангагдаж, 5 эх баригчийг сургалтанд хамруулж, 2 их эмчийг эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр резидентээр сургаж байна. Аймаг, сумын хэмжээнд бүх жирэмсэн эхчүүд болон хүссэн хэн нэгэнд ХДХВ/ДОХ, БЗДХ-ыг оношлох оношлууртай болж, аймгийн ЭМГ-т сайн дурын зөвлөгөө өгөх кабинеттай болж , сумын эмнэлэг амрах байрны дэргэд зөвлөгөө өгөх сургалтанд хамрагдсан эх баригч ажиллаж байна.

Рашаан сувиллыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд зонхилон тохиолдох архаг өвчнүүдийн чиглэлээр өөрийн орон нутагт байдаг рашаанд 7-14 хоногийн хугацаагаар явж 75 хувь нь ууж хэрэглэх байдлаар, 25 хувь нь орох, шавших байдлаар хэрэглэдэг.

Тухайн орон нутгийн хүмүүс сайн дураараа болон сумын удирдлагын зүгээс рашаан, булагийн усны эхийг хамгаалах ажлыг/хайслах, чулуугаар хашлага хийх, овоо босгон ймбаар, хаалт хийх/ хийдэг.

Аймгийн хэмжээнд орон нутгийн чанартай голдуу хэрэглэгддэг 25 нэрийн рашаан байдгаас улс, бүсийн чанартай ашиглагдах 2 рашаан байна. /Цэнхэр сумын халуун рашаан, Батцэнгэл сумын Хоршооллын халуун рашаан/

Орчны эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд орчны эрүүл байдлыг сайжруулан, аюулгүй нөхцлөөр хангахад юуны түрүүнд хувь хүмүүсийн орчинтойгоо зөв харьцах, орчны бохирдлоос сэргийлэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох асуудал чухал ач холбогдолтой юм.

Гэдэсний халдварт өвчний өвчлөл ихтэй аймгийн төв, сумдын 2-5 насны хүүхдийн голомтын хавьтагсдад өвчлөл ихтэй улиралыг угтан 810 хүнийг сайн дураар энгийн иммуноглобулинд хамруулсан байна. Балнадын вакцин, нян залгиур хэрэглэх ажил үйлчилгээний жагсаалтанд орсон 20 хүнийг сайн дураар вакцинд хамруулсан. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх ажилд ундны ус, хүнсний хангамж, хөрсний бохирдлыг багасгах асуудлаар сумдын засаг дарга, хурлын дарга нарт жил бүр мэдээлэл өгч сургалт зохион байгуулан ажиллаж байна. Эрдэнэбулган сумын хэмжээнд ЕБС, цэцэрлэгийн гар угаах, бие засах газрын стандартын шаардлагыг хангуулсан.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР

1. Өсвөр үе, залуучуудын үндэсний хөтөлбөр /2006, ЗГ-282/
2. Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр
/2002, ЗГ-274/
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр/2006, ЗГ-283/
4. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр
/2006, ЗГ-245/
5. Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд
хөтөлбөр/2008, ЗГ-25/
6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр /2002, /
7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах
үндэсний хөтөлбөр/2005, ЗГ-75/

Нийгмийн халамжийн салбарт 7 хөтөлбөр хэрэгжиж байна. Үүний 1 хөтөлбөр-70% тай бусад хөтөлбөрийн хувьд хэрэгжилт 40-60% -тай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд Италийн Засгийн газрын бус АИФО байгууллагын Тэгш дүүрэн хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 120 иргэнд 2,8 сая төгрөгний зээл олгон хөдөлмөр эрхлүүлж байна.

Хөдөөгийн агробизнес, Дэлхийн зөн ОУБ, ХЭД сангийн хөрөнгөөр 20 гаруй удаагийн сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй 300 гаруй иргэнийг мэргэжлийн сургалтанд хамруулж хөдөлмөр эрхлэх бололцоогоор хангаад байна.

Ар амин хүсэл үйлдвэрийн үйл ажиллагаанд 2009 онд ОНТНөөц хөрөнгөнөөс 2.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн байна. НХХЯ-аас ХБИргэдийг дэмжих төслөөс АР АХ үйлдвэр 5.4 сая төгрөгний санхүүжилт авч талх нарийн боовны үйлдвэрлэл эрхэлж 5 хүнийг ажлын байртай болгосон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр хэрэгжснээр

2009 онд 475 ядуу өрхийг сонгон авч эдгээр өрхийн гишүүдээс 227 иргэнийг нийтийг хамарсан ажилд оролцуулж 17.850 мян төг, 96 иргэнийг мэргэжлийг чиг баримжаа олгох сургалтанд хамруулж 10.5 сая.төгрөг, 26 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж 962.0 мян төг,

“Тогтвортой амьжиргаа 2” төслийн хүрээнд 2009 онд сумдаас нийт 230 төслийг хүлээн авч “Олон нийтийн санаачилгын сан”-гаас 102 төслийг 484.0 сая төгрөгийн санхүүжилттэй хэрэгжүүлж байгаагаас Боловсролын чиглэлийн 35 төсөлд 133.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн салбарын 21 төсөлд 87.9 сая төгрөгийн, дэд бүтцийн чиглэлийн 32 төсөлд 197.9 сая төгрөгийн бусад чиглэлийн төслүүдэд 64.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус зарцуулсан байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллага аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөл ХТХ-ийн дэргэд 35 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ”Хөгжилтэй агшин”, “Дуулиан-2020” заалны хөлбөмбөгийн тэмцээн зохиож явуулсан байна. Мөн хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч, гэмт хэрэгт холбогдсон 11 хүүхдийн ялыг хойшлуулж, аймгийн хорих байранд саатуулагдаж байгаа хүүхдүүдтэй уулзаж нөхцөл байдлыг судлан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хүүхэд, тэдний эцэг, эхийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сумдад

8 удаагийн сургалтыг зохион байгуулж 1200 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулсан байна.

ХУУЛЬ ЗҮЙН САЛБАР

1. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр /2003, УИХ-41/
2. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр /2002, УИХ-41/
3. Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр /2006, ЗГ-64/
4. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр /2005, ЗГ-234/
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /2007, ЗГ-225/
6. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр /2006, ЗГ-315/
7. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр /2006, ЗГ-263/
8. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр /2003, УИХ-48/
9. Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр /2008, ЗГ-78/

Манай аймгийн хувьд хууль зүйн салбарын 9 үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 5 хөтөлбөрийн хэрэгжилт 60-70%-тай , бусад хөтөлбөрийн хувьд 40-60%-тай байна.

Монгол Улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн болон эд хөрөнгийн тасагт зохион байгуулагдан онлайн сүлжээнд холбогдон архивт цаасан хэлбэрээр хадгалагдаж байгаа баримтуудыг мэдээллийн цахим санд оруулах ажлыг гүйцэтгэж байна. Хүн амын өрхийн болон хаягийн нэгдсэн бүртгэл, сонгуулийн насны иргэдийн бүртгэл, эд хөрөнгө өмчлөх, ашиглах, эзэмших, захиран зарцуулах , арилжих зэрэгтэй холбоотой эрхийн бүртгэлийг хууль, журмын дагуу гүйцэтгэж байна.

Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр аймгийн засаг даргын захирамжаар сар бүрийн 25-ны өдрийг согтууруулах ундаа худалдахгүй өдөр болгож иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж тусгай зөвшөөрөл, цагийн хуваарийн хэрэгжилтийг хангуулж зөрчил гарсан 19 иргэнд 115000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Мөн сумдад архидан согтуурахаас сэргийлэх талаар хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, аймгийн төвд 3 хэсгийн байцаагч, 5 багийн цагдаа, 6 олон нийтийн байцаагч ажиллаж хариуцсан газруудад эргүүл хийн хяналт тавьж байна.

Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиож байгаа ажлын үр дүн, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар телевиз, сонин хэвлэлээр олон нийтэд мэдээлсэн.

Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХЗХ-ийн дэргэд Эрх зүйн туслалцааны төвийг байгуулж аймгийн төвийн 5 багийн 225 иргэдийг хамарсан эрх зүйн сурталчилгааг зохион байгуулж ном, гарын авлагыг ард иргэдэд тараасан байна. Тус төвд 34 иргэн хандаж хууль зүйн зөвлөгөө авч, 34 хэрэг хүлээн авч үүнээс 29-ийг нь шийдвэрлэсэн байна. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, анхан шатны зөвлөгөө өгөх чиглэлээр албан бус сургалтыг 2 удаа зохион байгуулж 183 иргэнийг хамруулж, биечлэн болон утсаар, бичгийн хэлбэрээр 70 орчим лавлагаа өгсөн байна.

Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн архивт хадгалагдаж байгаа бүх баримтын агуулга, тоо бүртгэлд хамруулах талаар архивын 19 хөмрөгийн 1835 хадгаламжийн нэгжид үзлэг хийж шинэчлэн цахим санд оруулсан.
- Архивын баримтыг шалгасны үр дүнд 4 хөмрөгт танилцуулга, тойм заагчийг үйлдэж мэдээллийн сан бүрдүүлж байна.
- Архивын баримтын хадгалалтын нөхцлийг сайжруулахын тулд шинээр 16 хөмрөгийн 1989 хадгаламжийн нэгжид үзлэг хийж хэсэгчилсэн тооллого явуулж 2135 хадгаламжийн нэгжийг сэлбэн засч дахин үдэж эмхлэн цэгцэлсэн.

- Архивын үндсэн болон боломжит эх үүсвэрийг 26 сум, байгууллагын 1089 хадгаламжийн нэгжийн сан хөмрөгөөр баяжуулсан байна.
- Аймгийн ЗДТГ-т албан хэрэг хөтлөлтийн болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг автоматжуулахаар хэрэглээний зохих программыг хэрэглэж хэвшүүлсэн.

САНХҮҮ

1. Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөр /2007, ЗГ-264/
2. Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр /2005, ЗГ-202-2/
3. Төрийн албан хаагчдын орон сууц дэд хөтөлбөр /2007, ЗГ-221/

Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Төрийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, ард иргэдэд чирэгдэлгүй үйлчлүүлэх үүднээс Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүний эрхийн судалгааны төвтэй хамтран “Нэг цонх-ны үйлчилгээг 2009 оны 7 дугаар сараас нээн ажиллуулж байна. ”Нэг цонх “-ны үйлчилгээний байрыг засварлаж тохижуулахад орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөг зарцууллаа.

Энэхүү “Нэг цонх” -оор өдөрт дунджаар 80 иргэнд нийгмийн халамж, иргэний бүртгэл мэдээлэл, нийгмийн даатгал, газрын харилцааны чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэж банк, нотариат зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж иргэдэд үйлчилж байна.

Сум бүрт хүн ам, өрхийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж компьютерт шивэн ашигладаг болсноор иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөн зэрэг бүртгэлийн үйлчилгээг нэг цэгээс шуурхай авах боломж бүрдсэн.-

-Багийн төвд багийн Засаг дарга, хүний эмч, байгаль хамгаалагч зэрэг албан хаагчдыг байнга байршуулах шаардлага тавин ажилласнаар хөдөөгийн иргэд чирэгдэлгүй нэг цэгийн үйлчилгээ авч эхэлж байна. Тариат сумын Мөрөн, Өндөр-улаан сумын Хануй, Донгой, Цахир сумын Баянгол, Хашаат сумын Номгон, Хотонт сумын Өндөр-сант, Булган сумын Тусгалт зэрэг хөдөөгийн багийн 60 гаруй хувь нь багтаа төвлөрөн ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын орон сууц дэд хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газраас 2005 онд батлагдсан 40.000 орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2007 онд мөн Засгийн газрын 221 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын орон сууцны дэд хөтөлбөр батлагдаж энэ хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын бондын хөрөнгөөр сум бүрт төрийн албан хаагчдад зориулж 4-8 айлын, аймгийн төв бүрт 20-30 айлын орон сууц барихаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдаж 2007-2008 онуудад барилгын ажлуудыг зарим сумдад эхлүүлээд байсан. Гэвч 2008 – 2009 онд бондын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй тул дээрхи хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажил орон нутагт үндсэндээ зогсонги байдалтай байна.

Архангай аймагт хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явц

Тогтвортой амьжиргаа-2 төсөл

Тогтвортой амьжиргаа-2 төсөл нь Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны хооронд 2007.12.19-нд байгуулсан гэрээний дагуу хэрэгжиж байна. Тухайн төслийн хүрээнд 2009 оны байдлаар аймгийн 18 суманд 241.4 сая төгрөгийн 55 төслийг хэрэгжүүлж байна. Төслүүдийг нийгмийн салбараар нь авч үзвэл Боловсролын салбарт- 23 төсөл /Үүнд: Морин хуур уртын дуу, Үдийн цай, Сургуулийн гадаад орчны тохижилт, Ширээ сандал, Хүүхдэд ээлтэй орчин, Гэр цэцэрлэг гэх мэт төслүүд хэрэгжиж байна. /; Эрүүл мэндийн салбарт-11 /Эрүүл мэнд, Эхчүүдийн амрах байр, Эргэлтийн эмийн сангийн тохижилт, Эрүүл мэндийн сургалт г.м /, Нийтийн үйлчилгээний чиглэлээр -8 /Халуун ус, Хүнсний зах, Хогны машин зэрэг/; зам, гүүр засвар – 4; хүнс, хөдөө аж ахуйн салбарт – 4 /Ямаат, Бүлээн хошуу г.м./; байгаль орчны чиглэлээр-2, бусад салбарт-4 төсөл хэрэгжиж байна.

Мөн хүлээж авсан нийт төслүүдээс шаардлага хангахгүй 11 төслийг буцааж, зөвшөөрөгдсөн 96 төслийг санхүүжилт шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

Дэлхийн зөн ОУБ-ын Архангай аймаг дахь салбар төлөөлөгчийн газар

Дэлхийн зөн байгууллага нь 2009 онд аймгийн ихэнхи сумдад бизнес сургалтын төв байгуулах; өрхийн тариаланг дэмжих; гамшигт нэрвэгдсэн болон эмзэг өрхийг дэмжих; хүүхэд, багш нар, иргэдэд зориулсан төрөл бүрийн сургалт, лекц; шүдний үзлэг, худаг барих ; жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан сургалт, эмнэлэгт хүүхдийн өрөө тохижуулах; хогны менежментийн үйл ажиллагаа; зэрэг үйл ажиллагаа явуулж 150 сая долларийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хөдөөгийн ядуурлыг бууруулах ХХ Нэгж

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд бүх сумдад 13.9 сая төгрөгийн ногооны үр олгож, БМХХ-ны ТББ-г бэхжүүлэх сургалтыг 10 суманд 2.5 сая төгрөг зарцуулан зохион байгуулжээ. Мөн бичиг үсэг үл мэдэгчийг сургах сургалтыг сум бүрт зохион байгуулж, сум тус бүрт 342.4 төгрөг зарцуулсан байна. Үүнээс гадна ядуу өрхөд мал олгох, хүнсний ногооны хүлэмж олгох, бэлчээрийн худаг гаргах, нярайн тоног төхөөрөмж олгох зэрэг үйл ажиллагааг явуулсан байна.

Мерси Корпс хөтөлбөр

Мерси Кор төслийн хүрээнд хөнгөлөлтэй зээлд /96/ 400 гаруй сая төгрөгийн зээл олгож 150-иад сая төгрөгийн зээлийн нмэлт барьцаа гаргасан болно.

Гарын үсэг/тамга/:.....

Архангай аймгийн Засаг даргын газар

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(2009 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр, төслийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Биелүүлэх хугацаа	Хяналтанд авсан заалт	Хэрэгжилтийн явц	
				Тухайн жилд ажлын явц /хувь/	Хөтөлбөр, төсөл хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын явц /хувь /
А	1	2	3	4	5

Нэг. Үндэсний хөтөлбөр

БАЙГАЛЬ ОРЧИН

1.	Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрөөс ЗГ-82	1998-2021	3. Байгалийн нөөцийн зохистой ашиглалт, байгаль орчны хамгаалалт	65	75
2.	Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр ЗГ-50	1999-2010	4.1. Төрийн захиргааны байгууллагын үүрэг 4.1.1, 4.1.2 4.2.Нутгийн захиргааны байгууллагын үүрэг 4.2.2, 4.2.3, 4.2.4	65	80
3.	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр ЗГ-25	1999-2015	19. Ой хээрийн түймрээс сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор авах арга хэмжээ 19.1,19.5,19.7, 22. Байгалийн гамшгийн хяналт шинжилгээний	60	70

			сүлжээг өргөжүүлэн хөтөлбөрийн хугацаанд дэс дараатай хэрэгжүүлж хяналтын тогтолцоог шинээр бүрдүүлэх арга хэмжээ авна. 23.6, 24.5, 25.3		
4.	Байгаль орчны салбарын боловсон хүчний тухай хөтөлбөр БОС-52	2000-2010	8. Байгаль орчны яамнаас салбарын боловсон хүчний талаар баримтлах бодлогын удирдлага, зохион байгуулалт	50	80
5.	Чанарын болон байгаль орчны удирдлага /менежмент/ -ийг дэмжих үндэсний хөтөлбөр ЗГ-146	2002-2016	4.4. Байгаль орчны талаархи үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож, эко-тэмдэг хэрэглэх журам нэвтрүүлэх	50	70
6.	Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр ЗГ-163	1996-2016	2,3,4,5	50	75
7.	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний	2006-2020	2.1, 4.1, 5.1, 5.3	50	70

	хөтөлбөр ЗГ-99				
8.	Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр ЗГ-309	2006-2010	2.7, 3.3, 4.4, 5.4, 5.5	50	75
9.	Агаарыг хамгаалах үндэсний хөтөлбөр ЗГ-82	1999-2010	1, 2	60	75
10.	Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр ЗГ-129	1999-2030		50	70
11.	Усны үндэсний хөтөлбөр ЗГ-43	1999-2010		80	80
12.	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр ЗГ-141	2003-2012	5.3.5, 5.3.7, 5.3.8, 5.4.2, 5.4.3	60	75
13.	Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр ЗГ-105	2002-2010	3.3.1, 3.3.5, 3.4.4, 3.6.1, 3.6.2	50	75
14.	Ойн тухай үндэсний хөтөлбөр ЗГ-248	2001-2015	А. Ой хамгаалах ажлын хүрээнд 1.б, 2.а, 2.в, 3.а,б,в Б. Ойг зохистой ашиглах ажлын хүрээнд 1.а,б,в	65	65

			2.а,б,в 3.б В. Ойг нөхөн сэргээх ажлын хүрээнд 1.б,г, 2.г		
15.	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр ЗГ-44	2005-2035		65	70
16.	Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр ЗГ-121	2003-2010	3.3, 3.3.3, 3.3.4, 3.3.5	50	75
17.	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-267	2008-2015	3.2, 3.2.1, 3.2.2, 3.2.3, 3.2.4, 3.3, 3.3.1, 3.3.4, 3.3.5, 3.3.6	50	30
18.	Ойн хортон шавьж болон өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөр ЗГХТ-5	2004-2015		55	75
19.	Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр ЗГ-	1998-2010		50	75
БОЛОВСРОЛ СОЁЛ					
1.	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр ЗГ-244	2004-2012	17	80	70
2.	Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний	2001-2010	МД 1.1, 1.3, 6.2, 6.1, 4.4, 4.2, 6.3, 6.4	65	80

	хөтөлбөр ЗГ-120				
3.	Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-316	2008-2015	МД 2.1, 2.2, 2.3, 3.4	80	70
4.	Зайны сургалтын үндэсний хөтөлбөр ЗГ-14	2002-2010	23	80	80
5.	Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр ЗГ-293	2008-2020	20, 2.14, 2.5, 2.6, 2.11, 2.20	80	70
6.	Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр ЗГ-194	2006-2010		80	80
7.	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр ЗГ-196	2008-2015	18,10, 3.1, 2.3,4;	80	70
8.	Морин хуур, уртын дууны үндэсний хөтөлбөр ЗГ-43	2005-2014	19	75	70
9.	Монгол хөөмий хөтөлбөр ЗГ-159	2007-2014		40	30
10	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр ЗГ-303	2007-2015	4,	75	65

11.	Монголын уламжлалт бий, биелгээ хөтөлбөр ЗГ-10	2009- 2014		60	20
-----	---	------------	--	----	----

ХӨДӨӨ АЖ АХУЙ					
1.	Хөдөөгийн айл, өрхийн цахилгааны эх үүсвэр, мэдээллийн хэрэгслийн хангалтыг сайжруулах дунд хугацааны хөтөлбөр ЗГ-49	1995-2020		75	70
2.	Нэг суурин - нэг бүтээгдэхүүн хөтөлбөр ЗГ-138	2005-2012		70	60
3.	Малын чанар сайжруулах хөтөлбөр ЗГ-93	2006-2015		80	70
4.	Экологийн цэвэр бүтээгдэхүүн хөтөлбөр ЗГ-50	2006-2015		60	65
5.	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр ЗГ-64	1999-2010		80	90
6.	Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр ЗГ-242	2001-2010		80	90
7.	Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр ЗГ-32	2009-2016		65	20
8.	“Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр ЗГ169	2004-2012		80	70
9.	“Сүү” үндэсний хөтөлбөр ЗГ-239	2006-2020			

				75	65
10.	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр	2003-2015		70	60
11.	Фермерийн аж ахуйг дэмжих хөтөлбөр	2002-2010		60	85
12.	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх үндэсний хөтөлбөр ЗГ-103	1998-2020		65	70
13.	Малын тэжээл хөтөлбөр ЗГ-283	2007-2015		70	65
14.	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр ЗГ-70	2008-2010		75	85
15.	“Ноос” дэд хөтөлбөр ЗГ-26	2001-2010		60	85
16.	“Арьс шир” дэд хөтөлбөр ЗГ-114	2001-2010		55	85
17.	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр ЗГ-64	2005-2010		50	85

ЭРҮҮЛ МЭНД

1.	Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр ЗГ-150	2006-2015		60	70
2.	Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр ЗГ-245	2005-2015		55	70
3.	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр ЗГ-246	2005-2013		60	70
4.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 3 дахь	2007-2015		60	70

	хөтөлбөр ЗГ-52				
5.	Йод дутлын эмгэгтэй тэмцэх 3-р хөтөлбөр ЗГ-85	2007-2011		55	80
6.	Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-251	2002-2010		55	85
7.	Сохорлоос сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр ЭМС- 191	2000-2010		55	85
8.	Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөр ЭМС-194	2000-2010		60	85
9.	Хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөр ЗГ-80	1997-2013		55	80
10.	Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр ЗГ-129	2002-2010		65	85
11.	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр ЗГ-150	2007-2012		60	85
12.	Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-139	2002-2013		60	80
13.	“Эрүүл мэндийн салбарын хөгжил-3”			55	70

	хөтөлбөр				
НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР					
1.	Өсвөр үе, залуучуудын үндэсний хөтөлбөр ЗГ-282	2006-2015		60	65
2.	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр ЗГ-274	2002-2015		60	65
3.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр ЗГ-283	2006-2015		60	65
4.	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр ЗГ-245	2006-2015		70	65
5.	Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр ЗГ-25	2008-2012		60	70
6.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2010		60	85
7.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр ЗГ-75	2005-2010		60	85
ХУУЛЬ ЗҮЙ					

1.	Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр УИХ-41	2003-2012		70	60
2.	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр ЗГ-315	2006-2010		70	85
3.	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-263	2006-2013		70	60
4.	Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр УИХ-48	2003-2012		70	75
5.	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох үндэсний хөтөлбөр ЗГ-78	2008-2012		60	50
6.	Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-64	2006-2012		60	50
САНХҮҮ					
1.	Нэг цэгийн үйлчилгээг байгуулах дунд хугацааны хөтөлбөр ЗГ-264	2007-2010		70	90

2.	Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр ЗГ-202	2005-2015		60	60
3.	Төрийн албан хаагчийн орон сууцны дэд хөтөлбөр ЗГ-221	2007-2015		40	60
	Нийт	76 үндэсний хөтөлбөр		58.3%	70.9%
Хоёр. Төсөл					
1.	Тогтвортой амьжиргаа-2 төсөл нь МУЗГ, Дэлхийн банкны хооронд 2007.12.17-нд байгуулсан санхүүжилтийн гэрээний дагуу хэрэгжиж байна	2008 -2011		99.1%	99.1%
2.	Мерси Корпс ХАБДХөтөлбөр 2004 оны 8 сард батлагдсан.	2004 -2013		94%	90%
3.	Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр , ЗГ-412-р тогтоолоор 2003 онд батлагдсан.	2003-2010		100%	98%
4.	Дэлхийн зөн ОУБ-ын Архангай аймаг дахь салбар төлөөлөгчийн газар			98%	97%

	Нийт	4 төсөл		97.5%	96%
--	-------------	----------------	--	--------------	------------

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ХАНГАХ
АЖИЛЛАГААНД ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛСАН ТОВЧ ДҮН**

(2009 оны жилийн эцсийн байдлаар)

№	Үзүүлэлт	ХӨТӨЛБӨР			
		Нийт зарцуулах хөрөнгө Мян/төг	Тухайн жилд төсөвлөсөн хөрөнгө Мян/төг	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө Мян/төг	Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш зарцуулсан хөрөнгө Мян/төг
	1	2	3	4	5
1.	Сургуулийн өмнөх болон бага, дунд			519.000	1.019.000

	боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-316				
2.	Морин хуур, уртын дууны үндэсний хөтөлбөр ЗГ-43			3.460.0	3.460.0
3.	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр ЗГ-303			895.5	895.5
4.	Малын чанар сайжруулах хөтөлбөр ЗГ-93	1.2 сая төгрөг		1.2 сая төгрөг	
5.	Экологийн цэвэр бүтээгдэхүүн хөтөлбөр ЗГ-50	5.0 сая төгрөг		5.0 сая төгрөг	
6.	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр ЗГ-70	10.0 сая төгрөг		10.0 сая төгрөг	
7.	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр ЗГ-25	100.000 Төгрөг		100.000 Төгрөг	
8.	Усны үндэсний хөтөлбөр ЗГ-43	33.0 сая төгрөг		10.0 сая төгрөг	23.0 сая төгрөг
9.	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр ЗГ-141	9.0 сая төгрөг		5.6 сая төгрөг	
10	Бичиг үсгийн	5.852.9 сая	4.954.0	4.954.0	7.356.0

	боловсролын үндэсний хөтөлбөр ЗГ-244	төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
11	Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр ЗГ-194	8.963.9 сая төгрөг	6.339.5 сая төгрөг	6.186.2 сая төгрөг	10.901.8 сая төгрөг
12	Ойн хортон шавьж болон өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөр ЗГХТ-5		40 сая төгрөг	40 сая төгрөг	
13	Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр ЗГ-50		240.0 мян	240.0 мян	480.0 мян
14	Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-120		550.0мян	578.0 мян	
15	Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр ЗГ-293		300.0 мян	639.5 мян	294.560 мян
16	Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр ЗГ-242	4 сая төгрөг		4 сая төгрөг	4 сая төгрөг
17	Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр ЗГ-25	6.468.00		6.468.00	4.312.00
18	Архив, албан хэрэг хөтлөлтөд	36 сая	9.5 сая	5.0сая	5.0сая

	мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр ЗГ-64				
	Нийт	119.584.000 төг	61.883.500тө г	104.840.20 0төг	60.718.860төг
ТӨСӨЛ					
1.	Тогтвортой амьжиргаа- 2 төсөл		710.060.0	694.881.3	694.881.3
2.	Мерси Корпс		94.636.0	88.939.0	350.694.0
3.	Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр /IFAD/	3.100.000.0	828.5 00.0	504.000.0	3.428.500.
	Нийт	3.100.000.000т өг	1.633.196.000т өг	1.287.820.300т өг	1.049.003.800т өг

Архангай аймгийн Засаг даргын тамгын газар

